

Д/д	Баталсан газар	Актын дугаар	Акт батлагдсан огноо	Актын нэр	Актын зүйл, заалт
1	Байгаль орчны сайд	18	1995.02.15	Журам батлах тухай /Улсын тусгай хамгаалалттай газар нутагт чонын тоог зохицуулах, зэрлэгшсэн нохой устгах журам/	3.Хамгаалалтын захиргаанд чоно авлах.зэрлэгшсэн нохой устгах ажлыг тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд багтдаг сум, орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулж нутгийн иргэдийг татан оролцуулна. 13.Анчинд агнасан чонын толгой бүрийг 3000 хүртэл суйлсан бэлтрэг бүрийг 1000 төгрөг, устгасан; нохой бүрд 15000 төгрөгөөр тус тус бодож урамшил олгоно. 14.Тусгай хамгаалалттай газрын захиргаа жилийн эцсээр чоно авлалт, зэрлэгшсэн нохой устгасан ажлын дүнг гаргаж, идэвхтэй оролцсон хүмүүсийг 15000 хүртэл төгрөгөөр урамшуулж болно.
2	Байгаль орчны сайд	98	1996.07.05	Журам батлах тухай	Нэгдүгээр хавсралт -Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны дүрэм 7.Агаарын чанарын шуурхай мэдээллийн сангийн мэдээг Ус цаг уур, орчны хянапт-шинжилгээний албаны ажилтан болон Ус цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн инженерүүд нэгтгэн дүгнэж Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон нийслэлийн Засаг даргын Тамгын газар, бохирдлын томоохон эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад тусгай бүр шуурхай мэдээлэх 13.Гэнэтийн осол, цаг агаарын хүнд нөхцлийн улмаас агаарын чанар эрс муудаж хүний эрүүл мэндэд ноцтой нөлөөлөх хэмжээнд хүрэх төлөв илэрвэл Ус цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын алба холбогдох байгууллага, нийт хүн амд шуурхай мэдээлэх Хоёрдугаар хавсралт -Агаарын чанарын мэдээлэл гаргах журам 12.Агаарын чанарын шуурхай мэдээллийг мэргэжлийн албанаас эрхлэн арав хоног бүр эмхтгэн төр, засгийн болон байгаль орчны төв орон нутгийн байгууллагыг хангана. Уг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж болно. 13. Агаарын чанарын архивийн мэдээллийг сонирхогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээний төлбөртэйгээр өгч болно.
3	Дэд бүтцийн хөгжлийн сайд/НЗД	89/А/55	1999.04.14	Дүрэм батлах тухай /Троллейбусны техник ашиглалтын дүрэм/	9. Хөдөлгөөний зохион байгуулалт 9.1. Зорчигч урсгалын хэмжээ, чиглэлээс хамааруулан үйлчилгээний чиглэлийн сүлжээг зохионо. Зорчигч, үйлчилгээний чиглэлийн сүлжээг батлах, өөрчлөлт оруулахыг хотын захирагчийн ажлын алба, тээвэр зохицуулалтын газар шийдвэрлэнэ.Чиглэлийн сүлжээнд өөрчлөлт орсон тухай бүрт хүн амд урьдчилж мэдэгдэнэ.
4	Гэгээрлийн сайд	234	1999.10.25	Дүрэм батлах тухай /Төрийн өмчийн	2.5.Үйл ажиллагааных нь чиглэлээр гаргасан иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.

				мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм/	
5	Гэгээрлийн сайд	246	1999.11.11	Журам батлах тухай /Техникийн болон мэргэжлийн сургуульд суралцагчийн мэдлэг чадвар, дадлыг үнэлж, дүгнэх үлгэрчилсэн журам/	Дөрөв.Сургалтын явцыг хянах, анги дэвшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох 4.1.Сургалтын агуулгын эзэмшилтийн байдлыг багш ээлжит хичээл бүрээр тооцож байхын зэрэгцээ сургуулийн захиргаанаас улиралд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн хяналт явуулж, үр дүнд хяналт-шинжилгээ хийж зөвлөмж боловсруулан багш, суралцагч, эцэг эхэд мэдээлж байна. 4.2.Хичээл бүрээр суралцагчийг үнэлэх агуулга, шалгуур үзүүлэлтүүд тодорхой байх бөгөөд түүнийг суралцагч, эцэг, эх, шалгагч бүгд мэддэг байна. 4.3.Анги дэвших болон улсын шалгалт авах хичээлийн нэр, хугацааг хичээлийн жилийн эхэнд багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, сургуулийн удирдах зөвлөлөөр баталгаажуулан суралцагч, эцэг, эхэд танилцуулна.
6	Байгаль орчны сайд/Сангийн сайд	154/201	1999.12.10	Журам батлах тухай /Байгаль орчны мэдээллийн төв санд бүрдүүлсэн мэдээг ашиглуулах, түгээх, орлого бүрдүүлэх, түүний орлогыг захиран зарцуулах журам/	Дөрөв. Мэдээллийн сангийн мэдээг үнэлэх, орлогыг бүрдүүлэх, зарцуулах 4.6.Мэдээллийн сангийн мэдээ, мэдээллийн ашиглалт, үйлчилгээнээс олсон орлогыг дараах үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд: 4.6.5.Байгаль орчны төв мэдээллийн санд мэдээ бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ховор мэдээ, зураг бүрдүүлж өгсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; 4.6.9.Иргэн, төрийн өмчийн бус, аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн буюу улсын захиалга, олон улсын байгууллага, гадаад орны тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгаа шинжилгээний ажлын тайлан, зураг, төсөл, байгалийн баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн талаарх мэдээг, мэдээллийн төв санд болон тухайн асуудалд хамаарах дэд, төрөлжсөн дэд сангуудад Төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Засаг даргын тамгын газар, экспертийн зөвлөлийн санал дүгнэлт болон сангийн захирагчийн зөвшөөрлөөр, зохих үнэ төлбөртэйгээр хүлээн авна.
7	Дэд бүтцийн хөгжлийн сайд	94	2000.03.31	Аргачилсан заавар батлах тухай /Орон сууц, иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх, судалгаа явуулах, даацын үндсэн бүтээцийг хүчитгэх, паспортжуулах заавар/	1.2.Энэхүү зааврын дагуу хуучин барилгын шинэчлэлт, өөрчлөлт, их засвар хийх, хүчитгэх ажлын зураг төсөл, техникийн шийдлийг зураг төслийн мэргэшсэн байгууллага боловсруулна. Илүү нарийн төвөгтэй болон хариуцлагатай нөхцөлд эрдэм шинжилгээний байгууллагуудыг татан оролцуулна. 2.3.Энэхүү зааврын 1.2-д заасны дагуу судалгаа явуулах зураг төслийн байгууллагын төлөөлөгч нь захиалагч байгууллагын төлөөлөгчтэй хамтран ажиллана. Шаардлагатай үед барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгчдийг, тодорхой материал, машин механизм г/м-ийг хэрэглэж бүтээц, хийцийг буулгах задлах асуудлуудыг шийдэх үүднээс оролцуулж болно.

8	Дэд бүтцийн хөгжлийн сайд	95	2000.04.03	Аргачилсан заавар батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт-Бүс нутгийн хөгжлийн төсөл боловсруулах аргачилсан заавар 2.7.Төслийн захиалга боловсруулах, орон нутагт суурь судалгааны материалыг бүрдүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, төслийн шийдэл гаргах, баталгаажуулах үйл ажиллагаанд тухайн чиглэлийн мэргэжлийн болон хяналтын байгууллагын холбогдох албан тушаалтан мэргэжлийн хүмүүсийг оролцуулах шаардлагатай.</p> <p>Хоёрдугаар хавсралт-Хот суурингийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар 2.7.Ерөнхий төлөвлөгөөний захиалга боловсруулах, орон нутагт суурь судалгааны материалыг бүрдүүлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, төслийн шийдэл гаргах, баталгаажуулах үйл ажиллагаанд тухайн чиглэлийн мэргэжлийн болон хяналтын байгууллагын холбогдох албан тушаалтан мэргэжлийн хүмүүсийг оролцуулах шаардлагатай.</p>
9	Дэд бүтцийн хөгжлийн сайд	115	2000.12.11	Үлгэрчилсэн дүрэм, гэрээ батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт-Аймаг, нийслэлийн тээвэр зохицуулалтын албадын үлгэрчилсэн дүрэм</p> <p>Хоёр. Тээвэр зохицуулалтын албаны үүрэг 2.11. Тээврийн тоон мэдээллийн систем бий болгох зорилгоор тээврийн статистик мэдээлэл нэгтгэн авч аймаг, нийслэлийн удирдлага болон холбогдох байгууллагуудыг мэдээ, мэдээллээр хангах, сонирхогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тээврийн мэдээ, мэдээллээр үйлчлэх;</p>
10	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	48	2001.05.11	Аргачлал, журам батлах тухай /Мэргэжил албан тушаалын тариф мэргэжлийн лавлах зохиох аргачлалыг нэгдүгээр, Хөдөлмөрийн норм, норматив тогтоох журмыг хоёрдугаар хавсралтаар/	<p>1. Ерөнхий зүйл Аливаа хөдөлмөрийн үр ашиг эцсийн дүнд ажлын цагийн хэмнэлтээр тодорхойлогддог тул түүний зарцуулалтыг нарийн судалж, цагийн нөөцийг илрүүлэн хөдөлмөрийн нормд оновчтой тусган хөдөлмөрийн бүтээмжийг өсгөхөд нормчлолын ажлын гол зорилт оршино.</p> <p>10.Салбарын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн норм, нормативыг боловсруулах, хянах ажлыг салбарын хэлэлцээрээр урьдчилан зөвшилцөж ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн салбарын хэмжээний хороо, зөвлөлтэй хамтран батална.</p> <p>13.Салбарын, нэгдсэн ба үлгэрчилсэн нормыг боловсруулах хянах ажлын төлөвлөгөөг улсын хэмжээний ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн төв байгууллагууд хамтран боловсруулна.</p> <p>3. Хөдөлмөрийн норм, нормативыг хянах, боловсруулах</p> <p>14.Салбарын, нэгдсэн ба үлгэрчилсэн хөдөлмөрийн норм, нормативыг хянах, батлах асуудлыг салбарын хэлэлцээрээр зохицуулна.</p> <p>15.Салбарын нэгдсэн ба үлгэрчилсэн норм-нормативыг холбогдох салбарын голлон гүйцэтгэх ба хамтрах байгууллагуудын ажлын хэсгээс хянаж боловсруулна. Ажлын хэсэг нь тухайн салбарын төрийн захиргааны байгууллага, түүний харъяа газруудын хөдөлмөр, цалин хөлс, нормчлол, шинжилгээний албад, харъяа үйлдвэр, аж ахуйн газрын норм зохиогч, хөдөлмөр цалин хөлсний ажилтнууд, ажил олгогчийн болон ажилтны</p>

				<p>төлөөллийн гишүүдээс бүрдсэн байна.</p> <p>16.Байгууллагын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн нормыг тухайн байгууллагын хөдөлмөр, цалин хөлс, нормчлолын ажил хариуцсан албад, мэргэжилтэн, ажил олгогчийн болон ажилтны төлөөлөлийн төлөөлөгчдыг оролцуулан боловсруулж хянан байгууллагын даргын тушаалаар батлуулна.</p> <p>21.Байгууллагын түвшинд боловсруулсан хөдөлмөрийн норм, нормативыг холбогдох тооцооны хамт, ажилтны төлөөлөгчидтэй зөвшилцсөнөөр байгууллагын даргад /ажил олгогчид/ танилцуулсны үндсэн дээр баталж мөрдүүлэх ба түүний хувийн хэргийг бүрдүүлж хадгална.</p> <p>22.Байгууллагын техник зохион байгуулалтын тухайн нөхцөл нь салбарын болон нэгдсэн, үлгэрчилсэн нормд тусгагдсанаас илүү дэвшилттэй байвал байгууллагын зүгээс ажилтны төлөөлөгчидтэйгөө зөвшилцсөнөөр уг дэвшилттэй талыг тусгасан техникийн үндэслэлтэй хөдөлмөрийн нормыг боловсруулан хэрэглэж болох бөгөөд энэ талаар уг нормыг баталсан байгууллагад мэдэгдэнэ.</p> <p>24.Шинээр батлагдсан норм, нормативыг дагаж мөрдөхөөр 2 долоо хоногоос доошгүй хугацааны өмнө ажилтанд байгууллагын зүгээс урьдчилан мэдэгдэнэ. Хэрэв урьдчилан мэдэгдэхгүйгээр шинээр тогтоосон буюу шинэчлэн нормыг мөрдүүлбэл уг норм, нормативыг хүчингүйд тооцно.</p> <p>27.Техникийн үндэслэлтэй хөдөлмөрийн нормыг боловсруулж нэвтрүүлэхэд идэвхтэй оролцсон инженертехникийн ажилтан, албан хаагчид, ажилтанд материаллаг урамшуулал үзүүлнэ.</p> <p>28.Техникийн үндэслэлтэй хөдөлмөрийн нормыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, түүнийг эзэмшихэд ажилтны идэвх сонирхлыг өрнүүлэх зорилгоор хянасан нормыг хэргэлсэн эхний 3 сард нэгжийн шинэ, хуучин үнэлгээний зөрүүгийн 80 хувь, дараагийн 3 сард 50 хувийг хянасан нормыг хэрэглэж байгаа ажилтанд нэмж олгоно.</p> <p>29.Ажилтнаас ажлын тэргүүний арга барилыг эзэмшсэний үндсэн дээр мөрдөж байгаа хөдөлмөрийн нормыг санаачлан хянаж тэр санаачилга нь тухайн цех тасагт амжилттай нэвтэрч, бүтээл дээшилсэн үед санаачилсан инженер техникийн ажилтан , албан хаагчид, ажилтанд шинэ норм нэвтрүүлснээс гарсан цалингийн фондын хэмнэгдлээс сарын тариф (албан тушаалын) цалин хүртэл хэмжээгээр 1 удаа шагнал олгож болно.</p>
11	Дэд бүтцийн сайд	42	2002.02.18	<p>Дүрэм батлах тухай /Аймаг, орон нутагт зорчигч, шуудан тээврийн үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм/</p> <p>4.Зөвлөл нь Засаг даргын тамгын газар, Тээвэр зохицуулалтын алба, Шуудан холбооны алба, Мэргэжлийн хяналтын алба, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөлтэй 5-аас 7 хүнтэй байх ба дарга, нарийн бичгийн даргатай байна.</p>

12	Хүнс, хөдөө аж ахуйн сайд	A/60	2002.04.22	Малын эмчид итгэмжлэл олгох түр журам батлах тухай	<p>1.3.Малын эмчид итгэмжлэл олгох ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо бүхий байнгын ажиллагаатай магадлан итгэмжлэх Зөвлөл / цаашид Зөвлөл гэх / гүйцэтгэнэ.</p> <p>4.1.Зөвлөл нь төрийн захиргааны төв байгууллага, мал эмнэлгийн мэргэжлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий 9 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байна.</p>
13	Байгаль орчны сайд	117	2002.06.01	Журам шинэчлэн батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт-Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлал явуулах журам</p> <p>Зургаа. Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, эрх</p> <p>9.аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн ТХГН-т үйл ажиллагаа явуулахдаа нутгийн иргэдийг аль болохоор түлхүү оролцуулж, тэдэнд ажлын байр бий болгох, хамтран ажиллах, ингэснээрээ тэдэнд орлогоо нэмэгдүүлэх боломж бий болгох</p> <p>12.ТХГН-ийн талаар гарсан хууль, дүрэм, журам болон холбогдох мэдээлэл авах</p> <p>13.тухайн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбогдсон төлөвлөгөө боловсруулахад хамгаалалтын захиргаа, захиргаа байхгүй бол сум, дүүргийн Засаг даргатай хамтран ажиллах</p> <p>14.тухайн ТХГ-ын хамгаалалтын захиргаа, сум дүүргийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон санал, шүүмжлэл, гомдол гаргах</p>
14	Дэд бүтцийн сайд болон Улсын мэргэжлийн хяналтын газар	71/134	2003.04.07	Дүрэм, журам батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт-Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм</p> <p>2.3.Улсын комисс ажиллахаас өмнө ажлын комисс ажиллаж уг барилга байгууламжийн акт баримтыг иж бүрдүүлэх, барилгын дутуу, чанаргүй ажлыг засуулж дуусгаад улсын комиссыг ажиллуулахад бэлтгэнэ.</p> <p>2.4.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын гишүүдэд дор дурьдсан байгууллагын төлөөлөгчид орно.</p> <p>ё) Захиалагч байгууллага ж) Гүйцэтгэгч байгууллага</p> <p>2.6.Ажлын комиссын бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөлөгчид орно.</p> <p>е) Гүйцэтгэгч байгууллага ё) Захиалагч байгууллага</p> <p>3.1.Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа байгаль орчинд хохирол учруулахгүй архитектур, хот байгуулалтын шаардлагад нийцсэн, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангасан тоног төхөөрөмж, материал, хийц хэсэг бүхий барилга байгууламжийг ашиглалтад оруулах үндсэн үүргийг улсын комисс хүлээнэ.</p>

15	Хууль зүй, дотоод хэргийн сайд/Хүнс, хөдөө аж ахуйн сайд/Батлан хамгаалахын сайд	81/A/39/18	2003.04.28	Журам батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт-Улсын хил нэвтэрсэн алдуул малын хөдөлгөөнийг зохицуулах журам</p> <p>6.3.Эзэн нь тогтоогдохгүй байгаа болон маргаантай, улсын хил нэвтэрсэн малыг таних ажиллагаанд орон нутгийн иргэдийн төлөөлөгч, хууль хяналтын байгууллагын ажилтнуудыг байлцуулах арга хэмжээ авна.</p> <p>Хоёрдугаар хавсралт-Улсын хил нэвтэрсэн алдуул малын хөдөлгөөнийг зохицуулах орон нутгийн салбар комиссын бүрэлдэхүүн</p> <p>Комиссын гишүүд:</p> <p>-Тухайн орон нутгийн мал эмнэлгийн алба, тасгийн эрхлэгч</p>
16	Дэд бүтцийн сайд	123	2004.06.16	Дүрэм батлах тухай /Барилга угсралтын ажлын төсөвт өртгийн индекс тооцох дүрэм/	2.1.Барилга угсралтын ажлын төсөвт өртгийн индексийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүнээс эрх олгосон байгууллагын захиалгаар энэхүү дүрмийн дагуу боловсруулж батлуулна. Баталсан индексийг барилгын системийн хэвлэл мэдээлэлд нийтэлж, олон нийтэд зарлана.
17	Дэд бүтцийн хөгжлийн сайд	163	2004.08.26	Барилгын норм ба дүрэм батлах тухай /Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм/	<p>Ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны бүх шаардлагыг уг ажлыг гүйцэтгэж буй байгууллага хариуцна.</p> <p>4.7.Ерөнхий гүйцэтгэгч буюу түрээслэгч нь үйлдвэрлэлийн талбай дээр туслан гүйцэтгэгч, түрээслэгчдийн оролцоотойгоор ажил гүйцэтгэхдээ:</p> <p>- тухайн үйлдвэрлэлийн талбай дээр бүх байгууллага, хувь хүний ажиллах аюулгүй ажиллагааг хангах арга хэмжээний төлөвлөгөөг тэдэнтэй хамтран боловсруулах;</p>
18	Хүнс, хөдөө аж ахуйн сайд/Байгаль орчны сайд	101/189/194	2005.07.15	Журам батлах тухай /Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам/	<p>3.2.Сэргээн засварлах, шинээр гаргахад (худгийн барилга, түүний дотор усан сан байгуулах, мал услах онгоц, талбай хийх гэх мэт) орон нутгийн захиргаа, малчид, хоршоо (малчдын бүлэг) хөрөнгө (цаашид "оролцооны хөрөнгө" гэх) гаргана. Энэхүү оролцооны хөрөнгө нь худагт, уст цэгийг сэргээн засварлах зардлын 10 хувиас доошгүй, шинээр барих зардлын 5 хувиас доошгүй байна.</p> <p>3.4. Сэргээн засварлах, шинээр гаргах худаг, уст цэгийг сонгохдоо дараах шалгуурыг баримтална:</p> <p>3.4.3.орон нутаг, малчид, хоршоо (малчдын бүлэг) нь оролцооны хөрөнгийг гаргах чадвартай гэдгээ тодорхойлсон байх;</p> <p>4.4.Худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, эзэмшүүлэхэд сум, дүүргийн Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>4.4.5.малчид, хоршоо (малчдын бүлэг)-ны санал, бэлчээрийн даац, услах малын тоог үндэслэн худаг, уст цэг ашиглалтын усны үйлчилгээний хөлс (худаг, уст цэг хариуцагчийн цалин, шатах, тослох материалын зардал, эвдрэл гэмтлийн засварын хөрөнгө, элэгдэл хорогдлын шимтгэл, бохирдол, хөлдөлтөөс хамгаалах арга хэмжээний зардал гэх мэт)-ийг "Усны тухай" хуулийн 15.1.3-т заасны дагуу эзэмшигчтэй зөвшилцөн сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоолгон, мөрдүүлэх;</p> <p>4.4.6.сэргээн засварлах, шинээр гаргасан худагт гарсан эвдрэл гэмтлийг засварлах талаар малчид хоршоо (малчдын бүлэг)-нд дэмжлэг үзүүлэх;</p> <p>4.7.3.үйлчилгээний талаарх санал хүсэлтээ холбогдох байгууллагад тавих.</p>

19	Сангийн сайд, Байгаль орчны сайдын тушаал	342/366	2006	Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд мөнгөн урамшуулал олгох журам	<p>1.Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг зөрчсөн аливаа үйлдлийг илрүүлэн арилгах, цаашид зөрчил гаргуулахгүй байхад иргэдийн оролцоо, идэвх санаачлагыг өрнүүлэх, дэмжих зорилгоор байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар үнэн зөв мэдээлэл ирүүлсэн, зөрчлийг илрүүлэхэд бодит туслалцаа үзүүлсэн иргэнд мөнгөн урамшуулал олгоход энэхүү журмыг мөрдөнө.</p> <p>Тав. Мэдээлэгчийг урамшуулах</p> <p>15.Аливаа зөрчлийг илрүүлсэн буюу ноцтой зөрчлийн талаар цаг үеэ олсон бодитой үнэн зөв, тодорхой мэдээлэл ирүүлсэн иргэнд мөнгөн урамшуулал олгоно.</p> <p>16.Мэдээлэлд дурдсан зөрчил нь хөдлөшгүй баримтаар нотлогдож эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлого нь зохих дансанд төлөгдсөний дараа уг торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувиар тооцож мөнгөн урамшууллыг мэдээлэгчид олгоно.</p>
20	Барилга, хот байгуулалтын сайд	10	2007.01.12	Барилгын дүрэм батлах тухай /Барилгын зураг төсөл зохиох, хайгуул судалгааны ажилд мөрдөх барилгын дүрэм/	<p>4.7.§Барилгажсан нутаг дэвсгэр талбайн хэмжээ, түүний хамрах орчинд байгаа үйлдвэрийн газрууд, хогийн цэг, ахуйн хатуу хог хаягдлын талбай, үйлдвэрийн хаягдал болон нефть хадгалах, шатахуун түгээх газрууд бусад бохирдлын эх үүсвэрүүдийн байрлалын зураглалыг тэдгээрийн боломжит шалтгаан ба шинж чанарын тайлбартай хамт гаргах (Энэ судалгааны ажилд шаардлагатай бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч болон холбогдох мэргэжлийн байгууллага, хүмүүсийг оролцуулна);</p> <p>§Маршрутын судалгааны үед тухайн барилга байгууламжийн орчинд сүүлийн 40-50 түүнээс дээш жилээр ажиллаж байсан, буулгасан үйлдвэрийн газруудын байршлыг тогтоох, үйлчилгээ, орон сууцны бохирын шугам сүлжээ, цуглуулах байгууламжид гарч байсан гэмтэл ослоос үүссэн хаягдал, химийн бордоо хэрэглэж байсан газар зэрэг ашиглалтын онцлогийг тодруулах зорилгоор оршин суугчдаас асуулга явуулах;</p>
21	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд	188	2009.07.22	Журам батлах тухай /Автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам/	<p>Дөрөв. Аюултай ачаа тээвэрлэлтэнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага</p> <p>4.3. Иргэд, байгууллага нь аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдолтой хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаарх санал, хүсэлтээ холбогдох төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.</p>
22	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд	06	2010.01.12	Журам батлах тухай /Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журам/	<p>10. Техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах байгууллага нь үйл ажиллагааныхаа талаар үйлчлүүлэгчдэд урьдчилан мэдэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.</p>

23	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд	111	2010.04.16	Дүрэм батлах тухай	<p>Арван тавдугаар хавсралт-Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах</p> <p>203.10 Мэдээлэл, мэдээллийг хамгаалах</p> <p>10.5. Осол, зөрчлийн шалтгаан нөхцөлд холбогдолтой бодит баримтыг нээлттэй болгож болно.</p> <p>10.6. Мэдээлэл зөвхөн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажил бус олон нийт, нийгэмд илүү чухал нөлөө үзүүлэх нь тогтоогдвол нийтэд нээлттэй болгоно.</p> <p>10.7. Хувь хүний мэдээллийг нээлттэй болгох нь холбогдох хувийн нууцтай холбоотой хууль тогтоомжуудыг зөрчөөгүй байвал мэдээллийг нээлттэй болгож болно.</p>
24	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	А/250	2010.07.22	Журам, гэрээ, гэрчилгээний загвар батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт- Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам</p> <p>Нэг. Нийтлэг үндэслэл</p> <p>1.1. Энэ журмын зорилго нь байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нутгийн иргэд нөхөрлөл байгуулах, хамтын менежментийг арга хэлбэрийг нэвтрүүлэх замаар зохион байгуулалттайгаар оролцох, байгалийн тодорхой төрлийн баялгийг иргэдийн нөхөрлөл хариуцан хамгаалах, ашиглах, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>Хоёр. Нөхөрлөлийг байгуулах</p> <p>2.1. Нутгийн иргэд өөрийн байнга оршин суугаа сум, дүүргийн нутаг дэвсгэрт байгаа байгалийн тодорхой төрлийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, эзэмших иргэдийн нөхөрлөлийг Монгол Улсын Иргэний хуулийн 476, 481 дүгээр зүйлд заасны дагуу байгуулна.</p> <p>2.2. Нөхөрлөлийн гишүүд хамтран ажиллах тухай гэрээ байгуулна. Гэрээндээ нөхөрлөлийн оноосон нэр, хаяг, албан бичгийн нүүр, тэмдэг, дундын сангийн эд хөрөнгийн төрөл, хэмжээ, дансны дугаар, дундын хөрөнгийг захиран зарцуулах, нөхөрлөлд элсэх, гарах журам болон гишүүний эрх, үүрэг, нөхөрлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, нөхөрлөлийн удирдлагыг сонгох журам, нөхөрлөлийн үйл ажиллагаа, татан буулгах зэрэг асуудлыг тусгасан байна.</p> <p>2.3. Нөхөрлөлийн гишүүдийн тоо 10-аас доошгүй байна. Нөхөрлөлийн ахлагч нь нөхөрлөлийнхөө бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний үндсэн дээр тухайн сум, дүүргийн иргэдийг нөхөрлөлдөө оруулж болно.</p> <p>2.4. Нөхөрлөлд хариуцуулах газар нутгийн хэмжээг нөхөрлөлийн гишүүдийн тоо, чадавхи, байгалийн нөөц баялагийн тархац, хэмжээ, тухайн газар нутгийн байгаль газар зүйн болоод экологийн онцлог зэргийг харгалзан тогтооно. Нөхөрлөлд нэг гишүүнд ноогдох газар нутгийн хэмжээ нь 500 га-гаас хэтрэхгүй байна.</p> <p>2.5. Нөхөрлөлийн хариуцан хамгаалах газар нутаг нь нөхөрлөлийн гишүүдийн байнга оршин суудаг сум, дүүргийн нутаг дэвсгэрт харьяалагдсан байна.</p> <p>Гурав. Байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах</p>

талаар хүсэлт гаргах, шийдвэрлэх

3.1. Нөхөрлөл нь байгалийн тодорхой төрлийн баялгийг хариуцан хамгаалах ашиглах, эзэмших талаарх хүсэлтээ сум, дүүргийн Засаг даргаар уламжлан Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд гаргана. Хүсэлт гаргахдаа дараахь баримт бичгийг бүрдүүлсэн байна.

Тав. Нөхөрлөлийн эрх, үүрэг

5.1. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааны хөтөлбөр, менежментийн төлөвлөгөөний биелэлтийн байдлыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулж, тайлан тавьж байна.

5.2. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа байгаль орчныг хамгаалах, хяналт шалгалт явуулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох, түүнчлэн учруулсан хохирлыг буруутай эдгээдээр нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах талаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд тавих, шаардах, шаардлагатай бол хуулийн байгууллагад хандах арга хэмжээ авна.

5.3. Хавар намрын хуурайшил ихтэй, түймрийн эрсдэл өндөр цаг үед байнгын эргүүл, жижүүр ажиллуулах, мэдээллийг сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд тогтоосон хугацаанд мэдээлж байна.

5.4. Нөхөрлөл нь гишүүдийнхээ дотроос идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулж болно. Идэвхтэн байгаль хамгаалагчид аймаг, нийслэлийн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч шаардлагатай дэмжлэг тусалцааг үзүүлнэ.

5.4. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа нэн ховор, ховор амьтан, ургамал, түүний амьдрах орчныг хамгаалах, өвөл, хаврын улиралд болон цаг уурын хүндрэлтэй үед амьтдын гол идээшил нутагт өвс тэжээл, хужир мараа тавьж өгөх, ус задгайлах, амьтны халдварт өвчний голомтыг тусгаарлах, амьтны нөөцөд халгаатай махчин амьтдын тоо толгойг зохицуулах, сийрэгжүүлэх, туршилт судалгаа явуулах зэрэг арга хэмжээг мэргэжлийн байгууллагын зөвлөмж, тусалцаатайгаар авч хэрэгжүүлнэ.

5.5. Хариуцан хамгаалж буй газар нутгийн төлөв байдал, нөөц, түүний өөрчлөлт, хөдөлгөөнд тогтмол ажиглалт хийж, мэдээллийг байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид өгч байна.

5.6. Бэлчээрийг улирлын хуваарь, сэлгээтэй ашиглах, гол горхи, булаг шанд, усны эхийг хамгаалах, цас борооны усыг цуглуулах, худаг гаргах зэргээр усжуулах, хадлангийн талбайг хаших, бордох, аргал хөрсөн түлдэг зуух болон нар, салхины эрчим хүч ашиглаж мод, бутлаг ургамлыг хэрэглээг багасгах замаар орчны доройтол, цөлжилт, хуурайшилтаас сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

5.7. Хариуцан хамгаалж байгаа газар нутагтаа мод бут, ургамал тарих, амьтан шилжүүлэн болон сэргээн нутагшуулах ажлыг мэргэжлийн байгууллагын зөвлөлгөө тусалцаатайгаар хэрэгжүүлнэ.

5.8. Сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрснөөр өөрийн хариуцан хамгаалж

				<p>байгаа газар нутгийн байгалийн бүх төрлийн нөөц баялгийг менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зохих төлбөр, хураамжтайгаар ашиглах замаар үр өгөөжийг нь тогтвортой хүртэх, худалдан борлуулах, олсон орлогын 50-иас доошгүй хувийг дундын сандаа төвлөрүүлэн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зориулан зарцуулна.</p> <p>5.9. Хариуцан хамгаалж буй газар нутгаа тэмдэгжүүлэх, хадлангийн талбай болон туршилт, судалгаа, нөхөн сэргээлт хийх газрыг хашиж, хамгаалж болох бөгөөд харин бусад иргэдийн нэвтрэх, аялал жуулчлал хийхэд саад учруулах, зэрлэг амьтны нүүдлийг хаах зэргийг хориглоно.</p> <p>5.10. Нутгийн иргэдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх болон нөхөрлөлийн үйл ажиллагааг иргэдэд тайлбарлан таниулах чиглэлийн сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулж байна.</p> <p>5.11. Нөхөрлөл нь улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төслийн хөрөнгөөр гүйцэтгэх байгаль хамгаалах чиглэлийн арга хэмжээ, төсөл хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтанд оролцох эрхтэй.</p> <p>5.12. Байгаль орчныг хамгаалах чиглэлийн уулзалт ярилцлага, семинар зөвлөлгөөн, мэргэжил шинээр олгох хийгээд давтан сургах сургалтанд гишүүдээ хамруулж байна.</p> <p>Зургаа. Бусад зүйл</p> <p>6.4. Нөхөрлөл нь хууль тогтоомж болон гэрээг зөрчиж байгаль орчинд хохирол учруулсан бол тухайн сум, дүүргийн Засаг дарга учруулсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулах, нөхөн сэргээлгэх арга хэмжээ авна.</p>
25	Сангийн сайд	112	2010.05.13	<p>ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Хөрөнгийн үнэлгээчнийг сонгон шалгаруулж эрх олгох, тусгай зөвшөөрлийг сунгах журам /</p> <p>Дөрөвдүгээр хавсарлт- Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам</p> <p>2.1. Мэргэжлийн зөвлөл нь хөрөнгийн үнэлгээний тайлантай холбоотойгоор үнэлгээчин, үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг зөвхөн үйлчлүүлэгчийн гомдол /цаашид "гомдол" гэх/-оор хянан хэлэлцэнэ.</p> <p>2.3. Мэргэжлийн зөвлөлийг дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Мэргэжлийн зөвлөлийн даргаар Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, нарийн бичгийн даргаар хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын ажилтанг томилно.</p> <p>2.4. Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын санал болгосоноор мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүний 2/3-оос доошгүй хувь нь хөрөнгийн үнэлгээний чиглэлээр мэргэшсэн байна.</p>
26	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд	226	2011.08.18	<p>Дүрэм батлах тухай /Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах,</p> <p>2.1.7."Хот байгуулалтын тухай" хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хот байгуулалтын баримт бичиг боловсруулахад олон нийтийн саналыг авч тусгана.</p>

				зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм/	
27	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	130	2012.03.26	Журам батлах тухай	Нэгдүгээр хавсралт- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах журам Хоёр. Аттестатчиллах үйл ажиллагааны зохион байгуулалт 2.2 Сургалтын байгууллагыг аттестатчилах ажлын хэсэг нь Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн үйлдвэр үйлчилгээний салбарын зөвлөл, Боловсрол, соёл, шинжлэх, ухааны яам, холбогдох салбарын яам, агентлаг, мэргэжлийн хяналтын байгууллага, мэргэжлийн бусад байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна.
28	Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд	181	2012.06.13	Барилгын норм ба дүрэм батлах тухай /Барилгын төсөв зохиох дүрэм, Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12/	3.11.6.Төсвийн норм, нормативыг хянах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг эрдэм шинжилгээ, туршилтын дууссан ажлын үр дүн, гадаадын болон өөрийн орны тэргүүний техник, технологи, шинэ дэвшилтэд материалын нэвтрэлт, төсвийн норм боловсруулах ажлын туршлага, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, хэрэглэх явцад төсвийн норм, нормативын талаар байгууллага, иргэдээс гаргасан санал, хүсэлт зэргийг үндэслэн гүйцэтгэнэ.
29	Зам, тээврийн сайд	120	2012.12.28	Журмыг батлах тухай	Хоёрдугаар хавсралт -Гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн ажиллах журам Хоёр. Ажлын хэсгийн зохион байгуулалт, эрх, үүрэг 2.1. Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа Төмөр замын тээврийн тухай хууль болон Монгол Улсын бусад хууль тогтоомж, Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам, энэхүү журмыг удирдлага болгоно. 2.2. Ажлын хэсэг нь ажлын хэсгийн дарга, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон холбогдох улсын байцаагч, мэргэжилтнүүдээс бүрдсэн орон тооны бус 7 гишүүнтэй байна. 2.11 Ажлын хэсгийн хурлыг дараах дэгийн дагуу явуулна: 2.11 Ажлын хэсгийн хурлыг дараах дэгийн дагуу явуулна: -Ажлын хэсгийн хуралд төрийн бус байгууллагын төлөөлөл саналын эрхгүйгээр оролцож болно. Гурав. Ажлын хэсгийн ажлын алба 3.2 Ажлын алба нь доор дурьдсан ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: хангаагүй тохиолдолд албан бичгээр мэдэгдэж, ирүүлсэн материалыг буцаана; -Гэрчилгээжүүлэлттэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, гэрчилгээжүүлэлтийн тухай зөвшөөрөгдсөн мэдээллийг цахим хуудсанд байршуулах.
30	Эрүүл мэндийн сайдын тушаал	180	2014. 05.30	Сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээ, Түүнд хяналт тавих журам	Хоёр. Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ 2.15.Сэтгэцийн эрүүл мэндийн хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээ, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд, сургууль хамт олон, гэр бүлийн гишүүдийн оролцоотойгоор явуулна.

31	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	A/03	2014.01.06	Журам батлах тухай /Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам/	Энэ журам БҮХЭЛДЭЭ оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан.
32	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд	A/115	2014.04.09	Журам батлах тухай /Хог хаягдлын мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх журам/	3.1. Мэдээллийн сан нь дараах дэд сангаас бүрдэнэ: 3.1.6. олон нийттэй харилцах дэд хэсэг; 6.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг. 6.4.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 3.1.6-д заасан олон нийттэй харилцах хэсэгт мэдээлэл оруулах эрхтэй. 6.4.5. Хог хаягдлын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх холбогдох мэдээллийг тоо, баримт, фото зураг, бичлэгээр баталгаажуулан олон нийттэй харилцах хэсэгт оруулж болно. 8.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн байгууллагууд мэдээллийн сангаар үйлчлүүлэх эрхтэй.
33	Хөдөлмөрийн сайд	A/123	2014.05.27	Журам шинэчлэн батлах тухай /Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт олгох журам/	Дөрөв. Хөдөлмөрийн төв биржийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа 4.1.Энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төв бирж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд: 4.1.5.хувийн биржийг бүртгэсэн болон бүртгэлээс хассан тухай олон нийтэд ил тод мэдээллэх; Зургаа. Бусад 6.1.Журмын хэрэгжилт, хувийн биржийн үйл ажиллагаанд Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн төв бирж, холбогдох бусад байгууллагаас хяналт тавих бөгөөд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэж болно. Энэхүү журмыг зөрчигчдөд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ
34	Зам, тээврийн сайд/Байгаль орчин ногоон хөгжлийн сайд	138/A/208	2014.06.02	Журам батлах тухай	Нэгдүгээр хавсралт -Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам 8. Бүртгэгч байгууллагын эрх, үүрэг: 8.4. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх хугацаа болон хамрагдах нутаг дэвсгэр, байрлалыг олон нийтэд урьдчилан өдөр тутмын буюу бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр 14-өөс доошгүй хоногийн өмнө мэдээлнэ.

35	Зам, тээврийн сайд	216	2014.09.18	<p>Журам батлах тухай /Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам/</p>	<p>Нэг. Нийтлэг үндэслэл 1.6. Хөдөлгөөн зохицуулалтын төв нь хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах, хөдөлгөөний нэгдсэн зурмагийн хэрэгжилтэнд хяналт тавих бөгөөд төрийн байгууллага болон олон нийтийг мэдээллээр хангаж ажиллана. Хоёр. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулахад тавигдах шаардлага 2.1.4. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын саналыг харгалзсан байх. Гурав. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах 3.4. Галт тэрэгний хөдөлгөөний зурмаг боловсруулах, түүнд өөрчлөлт оруулах явц болон тэдгээртэй хамааралтай мэдээллүүд нь суурь бүтэц эзэмшигчид бүрэн, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гаргасан саналын хүрээнд нь тус тус нээлттэй байна. Дөрөв. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн цаглабар 4.1.1.1. Суурь бүтэц эзэмшигч нь тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, иргэнээс өвлийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт тусгуулах саналыг жил бүрийн 8 дугаар сарын 05-ны дотор, зуны суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт тусгуулах саналыг 3 дугаар сарын 20-ны дотор авах ба санал авах тухай 21-ээс доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарласан байх; Тав. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах 5.2. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах тухай саналаа бичгээр гарган, үндэслэл, түүнийг нотолсон баримт, материалын хамт суурь бүтэц эзэмшигчид ирүүлнэ. 5.3. Суурь бүтэц эзэмшигч нь өөрийн суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулсан тухай бүрт хөдөлгөөний нэгдсэн зурмагт өөрчлөлт оруулах саналыг Хөдөлгөөн зохицуулалтын төвд энэхүү журмын 3.2.1-д заасны дагуу ирүүлнэ. 5.5. Галт тэрэгний хөдөлгөөний зурмагт өөрчлөлт оруулах явц, түүнтэй хамааралтай мэдээллүүд нь энэхүү журмын 3.3-д заасны адил хүрээнд нээлттэй байна</p>
36	Хууль зүйн сайд	А/190	2014.11.04	<p>Журам батлах тухай /Алдуул болон хулгайлагдсан малыг бүртгэх, мэдээлэх журам/</p>	<p>2.6.Алдуул болон хулгайлагдсан малыг нийтэд зарлан мэдээлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, мал бүхий иргэдийн бүлгийг оролцуулж болох бөгөөд цагдаагийн байгууллага тэдний дэмжлэг, туслалцааг авч болно. 2.13.Олон тооны болон өндөр ашиг шимтэй, онцгой үүлдэр угсааны, хурдан, жороо морь зэрэг мал алдсан, хулгайлагдсан тохиолдолд аймаг, орон нутаг, улсын хэмжээнд эрэн сурвалжлах, зарлах, мэдээлэх ажлыг малаа алдсан малчны дэмжлэгтэйгээр цагдаагийн байгууллага зохион байгуулж болно.</p>

37	Уул уурхайн сайд	108	2015.06.12	<p>Журам шинэчлэн батлах тухай /Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам/</p>	<p>Дөрөв. Геологийн судалгааны ажилд хяналт тавих 4.1.Төсөл гүйцэтгэгчийн ажлын үр дүн болон ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор хээрийн судалгааны болон суурин боловсруулалтын ажлын гүйцэтгэлд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагаас шуурхай хяналтыг гүйцэтгэн төсөл зохих арга, аргачлалын дагуу хэрэгжиж байгаа эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг шалгаж, аргачлалын зөвлөгөө өгнө. Шуурхай хяналтын комиссын бүрэлдэхүүнд салбарын тэргүүлэх эрдэмтэд, мэргэжилтнүүдийг оролцуулж болно.</p>
38	Хөдөлмөрийн сайд	A/114	2015.06.22	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай</p>	<p>Хоёр. Зөвлөлийн удирдлага, бүрэлдэхүүн 2.4.Зөвлөл нь тухайн байгууллагын ажилтны тооноос хамааран ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн 3-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.</p> <p>Гурав. Зөвлөлийн ажлын чиглэл 3.2.Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр төлөвлөгөө, төсөвт тусгах асуудлыг боловсруулах, шаардлагатай дүрэм, журмыг баталж, мөрдүүлэхэд санал өгөх, хамтран ажиллах; 3.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах ажлыг ажил олгогчтой хамтран хийх; 3.5.Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлэхэд оролцох, бүртгэл судалгаатай танилцах, ажил олгогчоос шаардлагатай мэдээлэл гаргуулж авах; 3.6.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, дүнг ажил олгогч, ажилтнуудад мэдээлэх; 3.7.Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ахуйн байрны орчин нөхцөл, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ, сувилгаатай танилцах, хоолны чанарт хяналт тавих, үр дүнг мэдээлэх; 3.8.Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадавхижуулах арга хэмжээг ажил ологчтой хамтран зохион байгуулах; 3.9.Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа талаар ажил олгогчийн тайлан мэдээллийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, зөвлөмж, шийдвэр гаргах;</p>
39	Хууль зүйн сайд	A/187	2015.08.28	<p>Журам батлах тухай /Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам/ <i>/ХЗДХС-ын 2016.12.26-ны өдрийн А/128 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/</i></p>	<p>Дөрөв. Бусад 4.4.Жолоочийн зөрчлийн онооны мэдээллийн сангийн баяжилт, нууцлалыг Цагдаагийн байгууллага хариуцаж ажиллах ба лавлах үйлчилгээтэй холбоотой ажлыг төрийн болон төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.</p>

40	Хууль зүйн сайд	A/188	2015.08.28	Журам батлах тухай /“Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”-ыг нэгдүгээр, “Зөрчилд оногдуулсан торгуулийн мэдэгдэх хуудасны загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар/	Тав. Мэдээллийн сан 5.1.Бэлэн бус торгуулийг бүртгэлжүүлэх, хуулийн дагуу ногдуулсан торгох шийдвэрийн биелэлтийг хангуулах, жолоочийн зөрчлийн оноо тооцох боломжийг бүрдүүлсэн мэдээллийн сантай байна. 5.2.Иргэд тээврийн хэрэгслийн улсын дугаар болон жолоочийн үнэмлэхний дугаараар өөрт холбогдох мэдээллийг авах боломжоор хангагдсан байна. 5.4.Мэдээллийн сангийн баяжилт, нууцлалыг цагдаагийн байгууллага хариуцаж ажиллах бөгөөд торгуулийн мэдэгдэх хуудсыг эзэмшигчийн хаягаар хүргүүлэх ажлыг шуудан, харилцаа холбооны байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.
41	Барилга, хот байгуулалтын сайд	246	2015.12.17	Журам батлах тухай /“Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”, “Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”/	Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журам 8.1.Мэргэжлийн байгууллагын эрх олгосон байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, байгууллага, иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.
42	Хууль зүйн сайд	A/08	2016.01.11	Журам батлах тухай /Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй, идэвх санаачлагатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд “Урамшуулал олгох журам”/	1.1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж, амжилт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө. 3.1. Урамшууллын хэмжээ нь аж ахуйн нэгж, байгууллагад 500,000 /таван зуун мянган/ төгрөг, иргэн, албан тушаалтанд 300,000 /гурван зуун мянган/ төгрөг хүртэл байх бөгөөд өргөмжлөл олгоно. 3.2. Урамшууллын хөрөнгийн эх үүсвэрийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.3-д заасны дагуу холбогдох зардлаас гаргана.
43	Зам, тээврийн сайд	37	2016.02.18	Норм болон техникийн дүрэм батлах тухай	Хоёрдугаар хавсралт -Авто замын бэлэн байдлын түвшинг үнэлэх, эдгээр үзүүлэлтүүдийг үндэслэн санхүүжүүлэх аргачлал 2.Авто замын бэлэн байдлыг үнэлэх 2.1.Авто замын бэлэн байдалд хяналт шалгалт хийж түвшинг үнэлэхдээ дараах зарчмыг баримтлана. Үүнд: 2.1.1.Авто замын арчлалт, засварын ажлыг сар бүр уг авто зам, замын байгууламжийг хариуцсан захиалагчийн төлөөлөгч, зөвлөх болон зам хариуцагчийн ерөнхий инженер, арчлалт засварыннэгжийн дарга, мастерыг оролцуулсан ажлын хэсэг дараа сарын 5-ны дотор багтааж шалгана.

					<p>Шаардлагатай гэж үзвэл ажлын хэсгийн бүрэлдэхүүнд зам хариуцагчийн захирал, орон нутгийн замын цагдаа, зам хэрэглэгчийн төлөөлөгчдийг оролцуулж болно. Хяналт шалгалтын үзлэгийг захиалагч, зөвлөх, байцаагч нар хэдийд ч, замын хэмжээ харгалзахгүй хийж болно. Ажлын хэсэг нь замын бэлэн байдлын үнэлгээг уг замд газар дээр нь явж үзлэг хийж 1, 2-р зүйлд заасанчлан хийц хэсгүүдэд өгсөн үнэлгээгээр тогтооно.</p> <p>Гуравдугаар хавсралт-Авто зам, замын байгууламжийн бүртгэлийг хөтлөх, бүртгэл-мэдээллийн цахим сан байгуулах журам</p> <p>2.Авто зам, замын байгууламжийн бүртгэлийг хөтлөх 2.10.Авто зам, гүүрийн бүртгэл, хөдөлгөөний эрчмийн тооллого явуулах, замын техник ашиглалтын байдалд судалгаа хийж, түвшин тогтоон үндсэн материал бүрдүүлэх ажлуудыг замын арчлалт,засварыгхариуцсан арчлалт, засварын нэгж болон зам хариуцагч байгууллагууд эрхлэн гүйцэтгэх ба эдгээр ажлыг замын норм, нормативын сангийн хөрөнгөөс санхүүжүүлнэ. Энэ ажилд мэргэжлийн холбоод, зөвлөх, энэ чиглэлийн эрдэм, шинжилгээ, сорилт туршилтын байгууллагуудыг гэрээний үндсэн дээр татан оролцуулж болно.</p>
44	Зам, тээврийн сайд	90	2016.04.12	Журам батлах тухай	<p>Нэгдүгээр хавсралт- Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам 3.14.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр авто үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг түдгэлзүүлсэн, хүчингүйд тооцсон тохиолдолд ангилал тогтоосон эрх бүхий байгууллага энэ тухай олон нийтэд мэдээлнэ.</p> <p>Хоёрдугаар хавсралт- Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засвар хийх журам 8.4.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр авто үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.</p>
45	Хөдөлмөрийн сайд	A/53	2016.03.03	Шаардлага, загвар батлах тухай /Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага, загвар/	<p>Нэг. Ерөнхий зүйл 1.2. Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан баримт бичгийн шаардлагыг нягталж, тусгай зөвшөөрөл олгох дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, ажил олгогч, мэргэжлийн холбоодын төлөөлөл зэрэг төлөөллөөс бүрдүүлж, Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.</p>

46	Сангийн сайд	82	2016	Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журам	<p>9.4 Ёс зүйн зөрчлийн улмаас мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хүчингүй болгох тухай Ёс зүйн хорооны санал, дүгнэлтийг Институтийн удирдах зөвлөл шийдвэрлэхдээ тухайн мэргэшсэн нягтлан бодогчийг заавал байлцуулна.</p> <p>9.5 Эрх цуцлах тухай асуудал хэлэлцэх Удирдах зөвлөлийн хурлын зарыг тухайн мэргэшсэн нягтлан бодогчид 2 удаа мэдэгдэх бөгөөд 3 дах удаагаа хуралд ирээгүй тохиолдолд Институтийн удирдах зөвлөлийн хурлаар асуудлыг шийдвэрлэнэ.</p>
47	Хууль зүйн сайд/Хүнс, хөдөө аж ахуйн сайд	А/160	2016.05.16	<p>Дүрэм батлах тухай /Мал хулгайлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх/</p>	<p>Нэг. Нийтлэг үндэслэл</p> <p>1.1.Энэхүү үлгэрчилсэн дүрэм нь Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийг баг, хороондажиллуулах, олон нийтийн үүсэл санаачлагыг дэмжих, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, иргэд, малчдын эргүүл, шалгалт зохион байгуулах, тэдний эрх, үүрэг, шагнал урамшууллыг олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>Хоёр. Малчдын бүлэг байгуулах, гишүүн, ахлагчийг сонгох</p> <p>2.1.Малчдын бүлэг нь баг, хорооны хэмжээнд, нутаг дэвсгэр, айл саахалт, ах дүү, төрөл садангаараа хоршиж байгуулагдаж болно.</p> <p>2.2.Малчдын бүлэг нь оноосон нэртэй байна.</p> <p>2.3.Малчдын бүлэг нь тухайн орон нутгийн иргэдээс бүрдсэн гишүүд, бүлгийн ахлагчтай байна.</p> <p>2.4.Малчид болон мал бүхий иргэд малчдын бүлэг байгуулах хүсэлт, үйл ажиллагааны хөтөлбөр, дүрмийг сум, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлснийг тус зөвлөл хянаж үзээд үйл ажиллагаа явуулах эрх олгоно.</p> <p>2.5.Бүлгийн гишүүнээр ажиллах санал хүсэлтээ өөрийн биеэр гаргасан 18 насанд хүрсэн тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудагял шийтгэлгүй, өмнө нь хулгайлах гэмт хэрэгт холбогдож байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна.</p> <p>2.6.Малчдын бүлгийн гишүүд нэг бүрийн холбогдох мэдээлэл бүхий бүртгэл хөтөлж бүлгийн гишүүний үнэмлэх олгоно.</p> <p>2.7.Бүлгийн гишүүд болон Орон нутгийн цагдаагийн байгууллагын саналыг харгалзан бүлгийн ахлагчийг гишүүдийн хурлаас томилж, чөлөөлнө.</p>

48	Барилга, хот байгуулалтын сайд	116	2016.06.22	Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг батлах тухай	“Барилгын доторхи ус хангамж, ариутгах татуурга” /БНБД 40-05-16/ барилгын норм ба дүрэм: 18.5.Гэр ба амины орон сууцны хороолол, зуслангийн ус хангамжийн системийг төсөллөхдөө түүний үйлчлэх хүрээнд хамрагдах дэвсгэр нутгийн хэмжээ, тэнд оршин суугчдын оролцоо, тэдгээрийн харъяалагдах орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр холбогдох хайгуул судалгаа, зураг төсөл зохиох барьж байгуулах зэрэг бүх ажлыг гүйцэтгэвэл зохино.
49	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	A/50	2017.03.27	Журам батлах тухай /Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам/	Дөрөв.Үнэлгээнд оролцогч талуудын эрх, үүрэг 4.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн үүрэг 4.2.2.Үнэлгээ, хөндлөнгийн баталгаажуулалтын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөт үнэлгээний хуваарийг олон нийтэд мэдээлэх; Зургаа. Үнэлгээний зохион байгуулалт 6.10.Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь сургалтын байгууллага, иргэний гаргасан өргөдөл, хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хөндлөнгийн үнэлгээний нэгдсэн хуваарийг төлөвлөж, товыг мэргэжлийн чиглэл, мэргэшлийн түвшин бүрээр ангилж, цахим хуудсанд байршуулна.
50	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	A/49	2017.04.19	Журам, дүрэм батлах тухай /Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах/	Нэг. Нийтлэг үндэслэл 1.1.Малын эмийн салбар зөвлөл ("цаашид "Эмийн зөвлөл" гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна. 2.3.Малын эмийн салбар зөвлөл нь холбогдох төрийн захиргааны болон хяналтын асуудал эрхэлсэн байгууллага, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцсон 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Гурав. Малын эмийн зөвлөлийн бүрэн эрх 3.1.Эмийн зөвлөлийн үүрэг 3.1.4.Мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэж буй эм, эмийн түүхий эдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эмийн мэдээлэл, зар сурталчилгааны агуулгын асуудлаар хяналт тавих, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах, энэ талаар нийтэд мэдээлэх; 3.1.9.Эмийн чанар, аюулгүй байдал, хүн, мал, амьтны биед үзүүлж байгаа нөлөөллийн талаар гарсан санал, гомдлын дагуу тухайн эм, бэлдмэлийг шалгалт туршилтад хамруулах,дүгнэлт гаргаж, нийтэд мэдээлэх;
51	Гэгээрлийн сайд	223	1999.10.20	Журам батлах тухай /Улс, аймгийн музейд үзмэр худалдан авах журам/	1. Музейн захирлын /эрхлэгч/ шийдвэрээр " Музейн үзмэр худалдан авах зөвлөлийг /цаашид "зөвлөл"-гэнэ/ байгуулна. 2.Зөвлөл нь музейн захиргаа, сан хөмрөг, эрдэм шинжилгээ /сурталчилгаа/,нягтлан бодох ажлыг төлөөлсөн 3-5 гишүүнтэй байна.

52	Боловсрол, шинжлэх ухааны сайд	А/293	2013.08.13	<p>Журам шинэчлэн батлах тухай /Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам /Хавсралт 1//</p>	<p>Нэгдүгээр хавсралт- Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам Гурав: Багшийн ажлыг үнэлэх, дүгнэх зохион байгуулалт Тухайн хичээлийн жилийн 2,4 дүгээр улиралд багшийн өөрийн үнэлгээг сургуулийн захирлын шийдвэрээр байгуулагдсан багш, ажилтан, эцэг эх, заах аргын нэгдлийн ахлагч, сургалтын менежерээс бүрдсэн баг магадлан баталгаажуулна.</p> <p>Хоёрдугаар хавсралт- Цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам Гурав. Үнэлгээний зохион байгуулалт 3.2. Багшийн улирал бүрийн өөрийн үнэлгээг тухайн байгууллагын нийт хамт олон болон эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг магадлан баталгаажуулна. Ажлын хэсэгт ажиллах эцэг эхийн төлөөллийн тоо тухайн байгууллагын багш, ажилтны тооноос цөөнгүй байна.</p>
----	--------------------------------------	-------	------------	---	--